

“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ

ИЛТГЭХ ХУУДАС

2025 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

“Шингэрүүлсэн шатдаг хий” худалдан авах ажлын явцын тухай

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар Захирамжийг үндэслэн “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхийн гэр, амины орон сууцны дулаалга, цахилгаан болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж холболт, суурилуулах, түүний хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам” хэрэгжүүлэх зорилгоор эхний ээлжид 2025-2026 оны халаалтын улиралд Баянгол дүүргийн 11, 16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 10, 11, 13 дугаар хорооны 5,000 өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд шаардагдах хийг худалдан авах ажлыг зохион байгуулсан.

Тус ажлын гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын “Уст-Кутскийн хий боловсруулах үйлдвэр” ХХК хуулийн этгээдтэй гэрээгээр шууд худалдан авахаар гэрээ байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар Захирамжийг үндэслэн “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхийн гэр, амины орон сууцны дулаалга, цахилгаан болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг тоног төхөөрөмж холболт, суурилуулах, түүний хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам” хэрэгжүүлэх зорилгоор эхний ээлжид 2025-2026 оны халаалтын улиралд Баянгол дүүргийн 11, 16 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 10, 11, 13 дугаар хорооны 5,000 өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд шаардагдах хийг худалдан авах ажлыг зохион байгуулсан.

Тус ажлын гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын “Уст-Кутскийн хий боловсруулах үйлдвэр” ХХК хуулийн этгээдтэй гэрээгээр шууд худалдан авах аргыг хэрэглэх болсон үндэслэл, холбогдох материалын хамт хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангахаар Үйлдвэрийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулагдсан шингэрүүлсэн шатдаг хийг нийлүүлэх газрыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд “Тавантолгой түлш” ХХК-ийн Төслийн удирдлагын газраас шингэрүүлсэн шатдаг хийн техникийн тодорхойлолтыг боловсруулж баталсан.

Техникийн тодорхойлолтод Пропан агууламж, жин хамгийн багадаа 97%, Этан жин хамгийн ихдээ 2%, Бутан/Изобутан, жин хамгийн ихдээ 3%, С5 болон илүү хүнд нүүрстөрөгчид, жин хамгийн ихдээ 3%, Хүхрийн агууламж хамгийн ихдээ 30мг/м³, Зэс хавтангийн корроз (37,8°C 1 цаг) хамгийн ихдээ 1 цаг, Метанол агууламж Хамгийн ихдээ 50мг/м³, Хийн даралт (илүүдэл) 45°C-д Хамгийн ихдээ 1,6МПа ажиллах горимтой байна. Шингэрүүлсэн шатдаг хий нь Монгол гэр, байшин халаах, хоол бэлтгэх, хийн халаалтын зуух плиткад хэрэглэх, 24 цаг тасралтгүй ажиллах горимтой байх зэрэг шаардлагуудыг техникийн тодорхойлолтод заасан.

Үйлдвэрийн газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангах нийлүүлэгчийг сонгон шалгаруулж өгөх хүсэлтийг “Тавантолгой түлш” ХХК-ийн Төслийн удирдлагын газарт хүсэлт хүргүүлсэн.

Уг худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах ажлын хэсгийг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн эхний хуралдаанаар Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад туршлагатай боловсон хүчин манай байгууллагад байхгүй учир энэ ажлыг “Таван толгой түлш” ХХК-ийн “Төслийн удирдлагын газар”-аас нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах хүсэлт хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар захирамжаар 5,000 айл өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд нийлүүлэгчийг холбогдох хуулийн хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулах эрхийг “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-т үүрэг болгосон.

Техникийн тодорхойлолтын дүгнэлтээр Оросын Холбооны Улсын “Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр” ХХК техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан болохыг “Тавантолгой түлш” ХХК-ийн “Төслийн удирдлагын газар”-аас тодорхойлсон.

Ажлын хэсгийн гишүүд 100 хувийн саналаар “Тавантолгой түлш” ХХК-ийн баталсан техникийн тодорхойлолт болон ажлын даалгаварт нийцсэн “Шингэрүүлсэн шатдаг хий”-ийг шууд худалдан авах хэлбэрээр гэрээ байгуулахаар шийдвэрлэв.

Техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг бүрэн хангасан Оросын Холбооны Улсын “Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр” ХХК-тай шингэрүүлсэн хий нийлүүлэх гэрээг байгуулсан.

Гэрээг байгуулах хэлэлцээрийг эцэслэн хэд хэдэн нөхцөлийг талууд харилцан тохиролцож, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. “Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр” ХХК-тай байгуулсан гэрээний 1.2 заалтад заасны дагуу гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гэж заасан.

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Оросын Холбооны Улсын “Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр” ХХК-руу эхний 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий худалдан авах захиалга хийсэн. Захиалгын дагуу 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөгөөр 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий хил давж ирсэн. 12 дугаар сарын 10-ны өдөр Толгойт өртөөнд 9 вагон шингэрүүлсэн шатдаг хийг Улаанбаатар Төмөр замын Толгойт өртөөнд “Таван толгой түлш” ХХК-ийн гэрээт агуулах Гор газ ХХК-ийн агуулахад хүлээн авсан.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БОЛОРМАА

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ БИЧИГ ХЭРГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ДУЛАМСҮРЭН